

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

## 1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд ...тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

## 2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		66.67%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>70</b>		<b>97.22%</b>

## 3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- 3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

#### 4. Үнэлгээний асуулга

#### БОДЬ ДААТГАЛ ХК

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>					
<b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>					
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-н үйл ажиллагааг зохицуулсан журамтай бөгөөд тус журмаар ТУЗ-н бүрэлдэхүүний чиг үүргийг нарийвчлан зохицуулсан.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Биелүүлж ажилладаг	“Залгамж халааны бодлого”-д зохицуулалтыг оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсанд байршуулна.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн <a href="https://bodi-insurance.com/">https://bodi-insurance.com/</a> цахим хуудас, хувьцаа эзэмшигчид цэсэнд <a href="https://bodi-insurance.com/shareholders/">https://bodi-insurance.com/shareholders/</a> хувьцаа эзэмшигчдын хувь хэмжээг, ТУЗ-ийн гишүүд цэсэнд <a href="https://bodi-insurance.com/board-of-members/">https://bodi-insurance.com/board-of-members/</a> гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, тайлан цэсэнд <a href="https://bodi-insurance.com/wp-content/uploads/2022/04/2021-%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D-0406.pdf">https://bodi-insurance.com/wp-content/uploads/2022/04/2021-%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D-0406.pdf</a> дэлгэрэнгүй мэдээллийг тус тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.	2	100%

4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын хороодын бүтэц үйл ажиллагааны журмаар зохицуулсан.	2	100%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийгшинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, шаардлагатай журмуудыг танилцуулдаг ба “Компани засаглал” гэрчилгээ олгох сургалтанд хамруулж, гэрчилгээ авсан.	2	100%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын үйл ажиллагааны журмын дагуу хариуцлага хүлээдэг.	2	100%
<b>ДҮН</b>				<b>12</b>	<b>100%</b>
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>					
<b>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</b>					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ийн 9 гишүүний 3 нь хараат бус гишүүн, хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэйгээр зарлаж, ХЭХ-аар хэлэлцүүлж сонгосон.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын үйл ажиллагааны журамд тусгаж ажилладаг. Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн ажилладаг.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын үйл ажиллагааны журамд тусгаж ажилладаг. Хорооны даргаар хараат бус гишүүн томилсон.	2	100%

	<i>гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>				
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын үйл ажиллагааны журамд тусгаж ажилладаг. Хорооны даргаар хараат бус гишүүн томилогдон ажиллаж байгаа.	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ -ын хороодын бүтэц үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг.	2	100%
ДҮН				10	100%
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг.	Компани нь мэдээлэл ил тод байдлыг хангах, мэдээллийн урсгалыг сайжруулах нийтлэг журмын хүрээнд улирал, хагас жил болон жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан болон бусад тогтмол, тухай бүр мэдээлэх мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээллэж ажилладаг.	2	100%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Биелүүлж ажилладаг.	Компанийн <a href="https://bodi-insurance.com/">https://bodi-insurance.com/</a> цахим хуудас, <a href="https://bodi-insurance.com/annual-report-2021/">https://bodi-insurance.com/annual-report-2021/</a> хэсэгт жилийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд хүргэн ажиллаж байна.	2	100%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс,</i>	Биелүүлж ажилладаг.	Компанийн <a href="https://bodi-insurance.com/">https://bodi-insurance.com/</a> цахим хуудас <a href="https://bodi-insurance.com/wp-content/uploads/2022/04/2021-%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D-0406.pdf">https://bodi-insurance.com/wp-content/uploads/2022/04/2021-%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D-0406.pdf</a> болон Хөрөнгийн бирж <a href="https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.p">https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.p</a>	2	100%

	эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.		df үй ажиллагааны тайланг байршуулан ажиллаж байна.		
ДҮН				6	100%
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусган ажиллаж байна.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ын үйл ажиллагааны журамд тусгаж ажилладаг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Биелүүлж ажилладаг	Одоогоор бүтэц чиг үүрэгт өөрчлөлт ороогүй байна.	2	100%
ДҮН				6	100%
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Эрсдэлийн чиг үүргийг Аудитын хороо давхар хариуцан ажиллахаар зохицуулсан.	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус	Биелүүлж ажилладаг.	Эрсдэлийн чиг үүргийг Аудитын хороо давхар хариуцан ажиллахаар зохицуулсан.	2	100%

	<i>хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>				
20	<b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</b>	Биелүүлж ажилладаг.	Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хүлэмжийг хийг бууруулах, байгаль орчны нөхөн сэргээлтийг дэмжих “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөн эхлэснээс хойш 3 дах удаагаа мод тарьж, олон нийтэд мэдээлэх байдлаар ажиллаж байна.	2	100%
21	<b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Биелүүлж ажилладаг.	Компани нь комплайнсын хяналтыг захиргааны ахлах менежерийн ажлын чиг үүрэгт хавсран гүйцэтгэх байдлаар хяналтын үүргийг хэрэгжүүлж байна.	2	100%
ДҮН				8	100%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>					
<b>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>					
22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	Биелүүлж ажилладаг.		2	100%
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	“Цалин урамшууллын бодлого”, “Компанийн урамшууллын журам”-ын хүрээнд тус тус зохицуулалтыг хийж байна. Цаашид компани Хүний нөөцийн бодлогод ажилчдын цалин урамшууллын бодлогыг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.	1	50%
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>	Цаашид хэрэгжүүлж ажиллана.	Цаашид цалин урамшууллын бодлогын баримт бичиг боловсруулах, “Хувь хүний нууцийн тухай” хууль болон бусад журмын нийцлэлийн хүрээнд үйл ажиллагааны тайланд тусган ажиллахыг зорих болно.	1	50%
ДҮН				4	66.66 %
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх</b>	Биелүүлж ажилладаг.	ТУЗ аас баталсан журмууд болон компанийн дотоод журмууд нь оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах чиглэгдсэн байдаг.	2	100%



	<i>удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>				
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</b>	Биелүүлж ажилладаг.	Компанийн вэбсайт үйл ажиллагааны тайлан <a href="https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf">https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf</a> Хөрөнгө оруулагчдад цэсэнд <a href="https://bodi-insurance.com/2022-meeting/">https://bodi-insurance.com/2022-meeting/</a> хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, дүрэм журмын танилцуулгыг тус тус байршуулан хэрэгжүүлж байна. Мөн олон нийтэд хувьцаа гаргах үеийн “проспектус”-т дагуу хэрэгжүүлж буй ажлыг үйл ажиллагааны тайлангаар дамжуулан оролцогч талуудыг мэдээллээр хангах, хамтран ажиллах боломжи хувилбарыг сонгон ажиллаж байна.	2	100%
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>	Биелүүлж ажилладаг.	Компанийн вэбсайт үйл ажиллагааны тайлан <a href="https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf">https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf</a> Хөрөнгө оруулагчдад цэсэнд <a href="https://bodi-insurance.com/2022-meeting/">https://bodi-insurance.com/2022-meeting/</a> хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, дүрэм журмын танилцуулгыг тус тус байршуулахын нийтэд ил тод хүргээмжтэй байдлаар хүргэж ажиллаж байна.	2	100%
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</b>	Биелүүлж ажилладаг.	Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, “Ёс зүйн журам” зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмаар ажилтан, даатгуулагч, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	2	100%
<b>ДҮН</b>				<b>8</b>	<b>100%</b>
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
<b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>					
29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Биелүүлж ажилладаг.	Бодь даатгал ХК-ийн дүрэм, Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодексийн хүрээнд “Ёс зүйн дүрэм”-ээр зохицуулалт хийж ажиллаж байна.	2	100%



30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэсэгчилэн биелүүлж ажилладаг.	Ёс дүрмийн хүрээнд ажиллаж байгаа. Цаашид тусгайлсан дүрэм, журмаар зохицуулах хийхээр төлөвлөж байна.	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийн 2.2.7 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчимд суурилан аливаа үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байна гэж зааж, зохицуулалт хийж байна.	2	100%
ДҮН				6	100%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Биелүүлж ажилладаг.	Компанийн вэбсайт үйл ажиллагааны тайлан <a href="https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf">https://mse.mn/issuers/activityreport/554_20220412065131report.pdf</a> Хөрөнгө оруулагчдад цэсэнд <a href="https://bodi-insurance.com/2022-meeting/">https://bodi-insurance.com/2022-meeting/</a> хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, дүрэм журмын танилцуулгыг тус тус байршуулахын нийтэд ил тод хүртгэмжтэй байдлаар хүргэж ажиллаж байна.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	Би Ди Сек ҮЦК-тай хамтран ажиллах чиглэлийн хүрээнд хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хамтран зохион байгуулах замаар хамтран ажиллаж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	Цар тахалын үед Би Ди Сек ҮЦК-тай хамтран ажиллах гэрээгээр цахимаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулсан ба санал хураалтыг тус компанийн технологийн шийдлээр хөрөнгө оруулагчдад хүртгэмжтэй байдлаар оруулсан.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Биелүүлж ажилладаг.	Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хэмжээнд шийдвэр асуудлыг хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан журмын хүрээнд хэлэлцэх асуудалд тусгаж, “Хувьцаа эзэмшигчдийн хурал”-д оролцсон хувьцаа эзэмшигчийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх боломжтой.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс	Биелүүлж ажилладаг.	“ТУЗ түүний хороодын бүтэц үйл ажиллагааны журам”-ын 9.2-т тусгайлан зохицуулсан	2	100%

	<i>сэргийлэх сонирхлын хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>		болно. 2022 оны эхний 3 улирлын байдлаар Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.		
<b>ДҮН</b>			10	100%	
<b>НЭГДСЭН ДҮН</b>			70	97.22 %	

-oOo-